



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/47-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn</p>
---	--

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.14 № 07

танай _____-ны № _____-т

ХОТОНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.ОЮУНАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцож 10,841.6 мянган төгрөгийг илүү олгосон;
2. Төсвийн хөрөнгөөр 9,000.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл болон биеийн тамирын хувцас худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалтууд, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам" батлагдсаны дагуу тус байгууллагын төсвөөс 43,902.0 мянган төгрөгийг албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшуулалд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн үйл ажиллагааны зардал, биеийн тамирын уралдаан тэмцээн, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, бусад, орон нутгийн нөөц хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа, улсын баяр наадам арга гэсэн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,050,982.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,047,816.3 мянган төгрөгийг зарцуулж, 3,166.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн. Төсвийн үлдэгдэл нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 14 зорилт 102 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 44 арга хэмжээ нь дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 31 арга хэмжээ 80-89 хувь, 10 арга хэмжээ 70-79 хувь, 17 арга хэмжээ 60-аас доош хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 81.9 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,097,348.47	75,653,334.86
35	БАРАА МАТЕРИАЛ	46,097,348.47	55,813,334.86
351	Түүхий эд материал	10,000,000.00	10,000,000.00
3511	Тусгай зориулалттай материал	10,000,000.00	10,000,000.00
354	Хангамжийн материал	36,097,348.47	45,813,334.86
3541	Бичиг хэргийн материал	1,022,775.00	1,022,775.00
3542	Аж ахуйн материал	32,082,559.86	44,790,559.86
3544	Түлш, шатах тослох материал	2,992,013.61	0.00
36	НӨӨЦИЙН БАРАА		19,840,000.00
361	Барааны нөөц		19,840,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,386,132,894.32	2,576,292,420.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,386,132,894.32	2,576,292,420.80
392	Биет хөрөнгө	2,346,122,894.32	2,536,282,420.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,309,081,064.70	1,416,496,489.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-284,565,525.59	-282,873,821.13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	349,416,545.00	369,791,483.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-123,406,897.80	-146,117,803.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,539,285.00	124,339,285.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,632,984.68	-52,198,716.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,560,053.00	31,560,053.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,044,400.54	-24,238,180.15
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	49,999,993.00	49,999,993.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,694,594,885.00	1,798,515,692.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-687,419,122.77	-748,992,053.71
393	Биет бус хөрөнгө	40,010,000.00	40,010,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,010,000.00	40,010,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,432,230,242.79	2,632,105,755.66
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,432,230,242.79	2,632,105,755.66
51	Засгийн газрын хувь оролцоо	2,432,230,242.79	2,651,945,755.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	543,423,467.37	543,423,467.37
51101	Өмч: - төрийн	543,423,467.37	543,423,467.37
512	Хуримтлагдсан үр дүн	1,015,549,546.18	1,235,265,059.05
5121	Өмнөх үеийн үр дүн	1,015,549,546.18	1,015,549,546.18
5122	Тайлант үеийн үр дүн	0.00	219,715,512.87
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,257,229.24	873,257,229.24
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,432,230,242.79	2,632,105,755.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	989,247,794.00	1,387,437,433.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	374,531,545.00	318,925,008.1
120	Нийтлэг татварын бус орлого	374,531,545.00	318,925,008.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,757,100.00	12,472,091.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,757,100.00	12,472,091.10
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	362,774,445.00	271,092,117.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал		35,360,800.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	614,716,249.00	1,068,512,425.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,362,749.00	23,699,825.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	2,050,000.00

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,362,749.00	17,649,825.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	603,353,500.00	1,044,812,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	603,353,500.00	1,044,812,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	816,032,705.90	1,135,909,120.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	816,032,705.90	1,115,009,120.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	810,933,009.90	1,058,638,731.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,957,790.58	621,550,268.75
210101	Үндсэн цалин	304,970,699.92	402,651,623.83
210102	Нэмэгдэл	66,540,090.66	218,898,644.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,600,000.00	0.00
210104	Урамшуулал	21,847,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,849,429.57	76,830,320.37
210201	Тэтгэврийн даатгал	34,415,509.32	52,318,442.38
210202	Тэтгэмжийн даатгал	4,018,166.90	6,147,816.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,572,983.06	4,718,861.44
210204	Ажилгүйдлийн даатгал	805,716.68	2,340,431.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,037,053.61	11,304,769.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,693,600.00	27,693,600.00
210301	Гэрэл, цахилгаан	7,157,119.81	7,759,930.50
210302	Түлш, халаалт	17,536,480.19	19,933,669.50
2104	Хангамж, бараа материалын зардал	59,284,361.58	76,339,069.16
210401	Бичиг хэрэг	10,066,618.00	19,854,805.00
210402	Тээвэр, шатахуун	31,501,226.39	41,590,257.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,165,537.19	4,586,087.55
210404	Ном, хэвлэл	187,500.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,496,260.00	8,097,919.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,867,220.00	2,210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,602,334.00	14,853,120.00
210604	Урсгал засвар	6,602,334.00	14,853,120.00
2107	Томилолт, зочны зардал	3,991,174.66	5,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,991,174.66	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,297,149.00	44,454,802.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,497,149.00	41,300,194.00
210803	Даатгалын үйлчилгээ	790,476.00	455,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	9,524.00	524,548.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	175,000.00
210807	Газрын төлбөр	0.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	243,257,170.51	194,730,351.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,539,000.00	62,032,760.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,020,000.00	3,965,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	197,698,170.51	128,732,590.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,099,696.00	56,370,388.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,900,000.00	46,902,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	43,902,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	3,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,199,696.00	9,468,388.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,199,696.00	9,468,388.63
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	20,900,000.00
	Дотоод эх үүсвэрээр	0.00	20,900,000.00
221001	Их засвар	0.00	20,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	900,000.00

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	173,215,088.10	248,715,512.87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	29,000,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	29,000,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-29,000,000.00
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	173,215,088.10	219,715,512.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	626,473,349.00	1,080,984,516.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,757,100.00	12,472,091.10
120	Нийтлэг татварын бус орлого	11,757,100.00	12,472,091.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,757,100.00	12,472,091.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,757,100.00	12,472,091.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	614,716,249.00	1,068,512,425.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,362,749.00	23,699,825.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,362,749.00	17,649,825.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	603,353,500.00	1,044,812,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	603,353,500.00	1,044,812,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	621,471,549.00	983,284,516.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	621,471,549.00	983,284,516.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,771,853.00	926,914,127.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,802,764.01	617,550,281.55
210101	Үндсэн цалин	284,909,651.68	398,651,636.63
210102	Нэмэгдэл	86,446,112.33	218,898,644.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,600,000.00	0.00
210104	Урамшуулал	21,847,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,719,456.14	76,830,320.37
210201	Тэтгэврийн даатгал	33,285,508.89	52,318,442.38
210202	Тэтгэмжийн даатгал	4,018,193.90	6,147,816.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,572,983.06	4,718,861.44
210204	Ажилгүйдлийн даатгал	805,716.68	2,340,431.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,037,053.61	11,304,769.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,693,600.00	27,693,600.00
210301	Гэрэл, цахилгаан	8,498,619.81	7,759,930.50
210302	Түлш, халаалт	16,194,980.19	19,933,669.50
2104	Хангамж, бараа материалын зардал	43,055,809.19	41,012,492.55
210401	Бичиг хэрэг	9,668,300.00	9,316,572.00
210402	Тээвэр, шатахуун	22,446,200.00	19,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,579,809.19	4,654,320.55
210404	Ном, хэвлэл	242,500.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,119,000.00	8,041,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	9,257,100.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	9,257,100.00
2107	Томиллолт, зочны зардал	3,991,174.66	5,000,000.00
210702	Дотоод албан томиллолт	3,991,174.66	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,221,449.00	53,339,833.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,421,449.00	50,185,225.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	455,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	699,548.00

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	0.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,787,600.00	96,230,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,000,000.00	92,265,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,787,600.00	3,965,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,699,696.00	56,370,388.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	46,902,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	43,902,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	3,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,199,696.00	9,468,388.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,199,696.00	9,468,388.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,001,800.00	97,700,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,001,800.00	97,700,000.00
	Дотоод эх үүсвэрээр	5,001,800.00	97,700,000.00
221001	Их засвар	0.00	20,000,000.00
222001	Тоног төхөөрөмж		900,000.00
223001	Бусад хөрөнгө	5,001,800.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	76,800,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,001,800.00	-97,700,000.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	842,334,458.08	2,259,015,154.69
2	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	173,215,088.10	173,215,088.10
3	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	1,015,549,546.18	2,432,230,242.79
4	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	1,015,549,546.18	2,432,230,242.79
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	219,715,512.87	219,715,512.87
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	1,235,265,059.05	2,651,945,755.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,050,982,600.00	1,047,816,302.47	3,166,297.53	99.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,982,600.00	954,816,302.47	3,166,297.53	99.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	911,080,600.00	907,914,302.47	3,166,297.53	99.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,235,900.00	617,550,281.55	2,685,618.45	99.57
210101	Үндсэн цалин	617,035,900.00	398,651,636.63	218,384,263.37	64.61
210102	Нэмэгдэл	3,200,000.00	218,898,644.92	-215,698,644.92	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,129,500.00	76,830,320.37	299,179.63	99.61
210201	Тэтгэврийн даатгал	52,319,500.00	52,318,442.38	1,057.62	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,202,900.00	6,147,816.55	55,083.45	99.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,961,900.00	4,718,861.44	243,038.56	95.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,240,500.00	2,340,431.00	-1,099,931.00	188.67

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	12,404,700.00	11,304,769.00	1,099,931.00	91.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,693,600.00	27,693,600.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	12,693,600.00	7,759,930.50	4,933,669.50	61.13
210302	Түлш, халаалт	15,000,000.00	19,933,669.50	-4,933,669.50	132.89
2104	Хангамж, бараа материалын зардал	41,012,600.00	41,012,492.55	107.45	100.00
210401	Бичиг хэрэг	9,011,000.00	9,316,572.00	-305,572.00	103.39
210402	Тээвэр, шатахуун	19,000,000.00	19,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,600,000.00	4,654,320.55	-54,320.55	101.18
210404	Ном, хэвлэл	360,000.00	0.00	360,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,041,600.00	8,041,600.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,457,100.00	12,457,100.00	0.00	100.00
210602	Тавилга	3,200,000.00	3,200,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	9,257,100.00	9,257,100.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,786,400.00	33,640,008.00	146,392.00	99.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,486,400.00	30,485,400.00	1,000.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	455,060.00	144,940.00	75.84
210804	Тээврийн хэрэгслийн татвар	700,000.00	699,548.00	452.00	99.94
210807	Газрын төлбөр	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,765,500.00	93,730,500.00	35,000.00	99.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,765,500.00	89,765,500.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	3,965,000.00	35,000.00	99.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,902,000.00	46,902,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,902,000.00	46,902,000.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,902,000.00	43,902,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	93,000,000.00	93,000,000.00	0.00	100.00
	Дотоод эх үүсвэрээр	93,000,000.00	93,000,000.00	0.00	100.00
221001	Их засвар19,	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.00
222001	Тонг төхөөрөмж	69,000,000.00	69,000,000.00	0.00	100.00
223001	Бусад хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,050,982,600.00	1,047,816,302.47	3,166,297.53	116.43
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,044,812,600.00	1,035,344,211.37	9,468,388.63	115.84
132001	Орон нутгийн төсвөөс	1,044,812,600.00	1,035,344,211.37	9,468,388.63	115.84
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,170,000.00	12,472,091.10	-6,302,091.10	202.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		12,472,091.10	-12,472,091.10	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	1	0.00 100.00

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0.00	100.00
6	Удирдах ажилтан	9	9	0.00	100.00
7	Гүйцэтгэх ажилтан	10	10	0.00	100.00
8	Үйлчлэх ажилтан	6	6	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,699,825.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,699,825.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,699,825.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,699,825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,699,825.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,699,825.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,699,825.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,649,825.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 48,068.8 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

Тайлант оны үнэ төлбөргүй хүлээн авсан 15,520.8 мянга, нөөц бэлтгэсэн 19,840.0 мянган төгрөгийн өвс тэжээл, худалдан авсан 12,708.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.1, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 21,155.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 10,841.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 10,314.2 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 21,155.8 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 7,356.9 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тайлант онд ЗДТГ-ын даргын 2024 оны 03 сарын 05-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллыг 5 албан хаагчид олгохдоо сүүлийн сарын үндсэн цалинг 6 дахин нэмэгдүүлж тооцон нийт 3,570,440 төгрөгийг илүү олгосон. Сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байх хугацаандаа буюу 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 11 дүгээр сарын хооронд төрийн үйлчилгээний албан тушаалд шилжин ажиллаж төрийн захиргааны албан тушаалд ажилласан хугацаа тасарсан санхүү албаны даргад 7,271,202 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.1-д "Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хотын төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчид орон нутагт тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөлийг баталгаажуулах, төрийн үйлчилгээг саадгүй, хүртээмжтэй хүргэх зорилгоор сум ... дүүрэгт төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоход энэ журмыг баримтална" 2.1-д "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал авна", 2.3-т "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Тайлант онд Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/27 дугаар захирамжаар Хөөвөр, Бургалтай, Улаан-Чулуу, Орхон багийн Засаг дарга нарт нийт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1,314.2 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн сангаас зардлын эдийн засгийн ангилал зөрчиж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" гэсний 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.1.6 "Сахилга баттай байх", 4.1.9 "Хариуцлагатай байх" 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.2.2. Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн А/84 дүгээр захирамж, засаг даргын зөвлөлийн 2024.10.22-ны өдрийн №13 дугаар шийдвэрийг үндэслэн засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас сумын төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, багийн засаг дарга, нийт 16 албан хаагчид бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 5,000.0 мянга, ЗДТГ-ын даргын 2024.12.10-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар албан хаагчдад биеийн тамир хувцас худалдан авахад 4,000.0 мянга нийт 9,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.2.3. Тус байгууллага нь сумын ЕБС-ийн халаалтын зуухнаас дулаанаар хангагддаг бөгөөд тайлант онд 19,933.7 мянган төгрөгийн 125.2 тн нүүрсийг худалдан авч зарцуулахдаа бөөн дүнгээр зарлагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" гэсний 5.1.4-д "Үнэн зөв байх" 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Цаашид ЕБС-тай гэрээ байгуулан сар бүр нэхэмжлэх хүлээн авсны дараа халаалтын зардлыг шилжүүлэн тооцоо нийлж баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

3.2.4. Тайлант хугацаанд шилэн дансанд 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 7 дугаар зүйлийн 7.1.1-т "... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан шилэн дансны мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх үүргийг хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мян.төг/			
			Үүнээс		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Тоо	Дүн	Тоо
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 6 албан хаагчид нийт 10,841.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.	1	10,841.6	1	10,841.6		
Улс төрийн албан тушаалтнуудад зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 1,314.2 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн сангаас олгосон.	1	1,314.2			1	1,314.2
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж нийт 9,000.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас, бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан.	1	9,000.0			1	9,000.0
Тайлант онд 125.2 тн нүүрсийг нийт дүнгээр зарлагадсан байна.	1	0.0			1	0.0
Нийт дүн	4	21,155.8	1	10,841.6	3	10,314.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Тайлант хугацаанд шилэн дансанд 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	0	1	0
Дүн	1	0	1	0